



ДАРХАН-УУЛ АЙМАГ  
"ДАРХАНЫ ДУЛААН СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар а/85

Дархан

Оны шилдгүүдийг шалгаруулах  
журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3, "Дарханы дулааны сүлжээ" ТӨХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын 3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Дарханы дулааны сүлжээ" ТӨХК-ийн оны шилдгүүдийг шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3. Энэ журмыг нийт ажилтнуудад сурталчлан танилцуулахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга (Ч.Чүлтэмтат)-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д. БАТЖАРГАЛ



"Дарханы дулааны сүлжээ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын  
2023 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 165 дугаар  
тушаалын хавсралт

### Оны шилдгүүдийг шалгаруулах журам

#### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1."Дарханы дулааны сүлжээ" ТӨХК-ийн ажилтныг өндөр бүтээмжтэй ажиллуулах, бүтээлч, идэвх санаачлагыг өрнүүлэх, тухайн жилийн ажлын гүйцэтгэлийг дүгнэж шилдгүүдийг шалгаруулах, урамшуулахад журмын зорилго оршино.

1.2.Энэ журмын эрх зүйн үндэслэл нь Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 43 дугаар зүйлийн 43.1.3, Эрчим хүчний салбарын хамт /тариф/-ын хэлэлцээр, компанийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээ болно.

#### Хоёр. Нэр дэвшүүлэхэд тавигдах шаардлага

2.1.Тухайн ажлын байранд 3-аас доошгүй жил ажилласан байх /тухайн жилд онцгой үр бүтээл гаргасан ажилтанд хамаарахгүй/

2.2.Цаг ашиглалт 85 хувиас дээш байх

2.3..Хөдөлмөрийн сахилга, технологийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр зөрчил гаргаагүй байх

2.4.Чанар, бүтээмж дээшлүүлэх ажил хийж гүйцэтгэсэн байх

#### Гурав. Шилдгийг шалгаруулах төрөл, тоо

3.1.Компанийн оны шилдгүүдийг дараах төрлөөр нэр дэвшүүлж шалгаруулна.

Үүнд:

3.1.1Оны шилдэг инженер техникийн ажилтан-1

3.1.2.Оны шилдэг албан хаагч-1

3.1.3.Оны шилдэг ажилтан-3

#### Дөрөв. Оны шилдгийг шалгаруулах

4.1.Алба, хэлтэс энэ журмын 2 дугаар зүйлийн 2.1-т заасан шаардлага хангасан ажилтныг өөрийн нэгжийн хамт олны хурлаар хэлэлцүүлэн шалгаруулж журмын хавсралтад заасан дүгнэх үзүүлэлтийн дагуу тодорхойлолтыг бичиж, товч анкет, хамт олны хурлын тэмдэглэлийн хамт 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор нэг хувь цаасаар Захиргаа удирдлагын хэлтэст ирүүлнэ.

4.2.Захиргаа удирдлагын хэлтэс ирүүлсэн материалыг шаардлага хангаж байгаа эсэхийг шалгаж бүртгэж авна. Хугацаа хэтэрсэн болон шаардлага хангаагүй материалыг хүлээн авахгүй.

4.3.Захиргаа удирдлагын хэлтэс хүлээн авсан материалыг ажлын 5 хоногт багтаан Гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулагдсан комисст танилцуулна.

4.4.Комисс материалыг хүлээн авч журмын хавсралтад заасан аргачлалаар дүгнэж компанийн оны шилдгүүдийг шалгаруулна.

#### Тав. Урамшуулал олгох

5.1.Журмын дагуу компанийн оны шилдэг ажилтнаар шалгарсан ажилтнуудыг хамтын гэрээнд заасан мөнгөн урамшуулал олгоно.

5.2.Оны шилдэг ажилтны шагналыг баярын хурал, шинэ жилийн баярын арга хэмжээн дээр хамт олны өмнө гардуулна.

"ДДС" ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2023 оны ᠘-р сарын ᠖-ны өдрийн ᠒᠗ тоот тушаалаар батлагдсан "Оны шилдгүүдийг шалгаруулах журам"-ын хавсралт

Оны шилдгүүдийг шалгаруулахад дүгнэх үзүүлэлт

№	Төрөл	Хамрагдах хүрээ	Нэр дэвшүүлэх албан тушаалтан	Дүгнэх үзүүлэлт
1	Оны шилдэг инженер	Алба, хэлтсийн дарга нар, бүх инженер техникийн ажилтан /механик/		<ul style="list-style-type: none"> <li>-Шинэ техник, технологи нэвтрүүлэх, технологийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, техник, эдийн засгийн үзүүлэлтийг дээшлүүлсэн байх-15 оноо</li> <li>-Өөрийн хийж буй ажилтай холбоотой шинэ арга барил, хандлага, шинэ санал санаачлага гаргаж нэвтрүүлсэн байх -10 оноо</li> <li>-Өөрийн ажилтай холбоотой ажлын доголдол, зөрчил гаргаагүй байх-5 оноо</li> <li>-Зардал бууруулах, үр ашиг нэмэгдүүлэх талаар өөрийн ажилтай холбоотой ажил хэрэгжүүлсэн байх -10 оноо, Нийт 40 оноо</li> </ul>
2	Оны шилдэг албан хаагч	Бүх албан хаагчид /харуул, үйлчлэгч, жолооч/	Ерөнхий инженер, алба, хэлтсийн дарга нар	<ul style="list-style-type: none"> <li>-Компанийн эрхэм зорилго, тухайн жилийн зорилтот түвшинг биелүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж үр дүнтэй ажилласан байх-15 оноо</li> <li>-Өөрийн хийж буй ажилтай холбоотой шинэ арга барил, хандлага, шинэ санал санаачлага гаргаж нэвтрүүлсэн байх -10 оноо</li> <li>-Өөрийн ажилтай холбоотой ажлын доголдол, зөрчил гаргаагүй байх-5 оноо</li> <li>-Зардал бууруулах, үр ашиг нэмэгдүүлэх талаар өөрийн ажилтай холбоотой ажил хэрэгжүүлсэн байх-10 оноо, Нийт 40 оноо</li> </ul>
3	Оны шилдэг ажилтан	Мэргэжилтэй ажилтнууд		<ul style="list-style-type: none"> <li>-Хариуцсан тоноглол, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангах, тоноглолын ашиглалтын түвшинг дээшлүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан байх- 15 оноо</li> <li>-Өөрийн ажлын хариуцлагаас шалтгаалсан тоноглолын зогсолт, аваар осол, саатал, гэмтэл гаргаагүй байх -10 оноо</li> <li>-Зардал бууруулах, үр ашиг нэмэгдүүлэх талаар өөрийн ажилтай холбоотой ажил хэрэгжүүлсэн байх-5 оноо, Нийт 30 оноо</li> </ul>